

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН 2023

“НЭТКАПИТАЛ САНХҮҮГИЙН ГРУПП”



АГУУЛГА

- Эрхэм зорилго
- Удирдлагын мэндчилгээ
- Онцлох үзүүлэлтүүд
- БОНЗ бүтэц ба компанийн засаглал
- Тогтвортой үйл ажиллагаа ба санхүүжилт
- Тогтвортой хөгжлийн алсын хараа

Эрхэм зорилго | **Mission**

- Дижитал эринд финтек хувьслаар манлайлна

Үнэт зүйл | **Value**

- Харилцагч төвтэй
- Хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалт
- Платформ бизнес модель
- Ажайл байгууллага
- Инноваци ба бүтээлч байдал.

Алсын хараа | **Vision**

- Дижитал банкиг таны гарт

Бидний соёл | **Culture**

- Эерэг хандлага
- Бүтээлч байдал
- Мэргэжлийн баг
- Залуу манлайлал
- Тасралтгүй суралцах
- Амжилтад тэмүүлэгч

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Б. ХУНШАГАЙ



НЭТКАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ ХХК-ИЙН нийт харилцагчид, түншүүд та бүхэндээ **2023** оны тайлангаа танилцуулж буйдаа таатай байна.

2023 онд компанийн нийт актив хөрөнгө 20 хувиар, харилцагчид олгосон зээлийн хэмжээ 44 хувиар өссөн байна. Бидэнд итгэл хүлээлгэн үйлчилгээ авдаг 100,000 гаруй үнэнч харилцагч, түншүүд болон компанийнхаа төлөө, харилцагч нарынхаа төлөө гэсэн сэтгэл, зүтгэлтэй 471 ажилтнууддаа талархал илэрхийлье.

Дижитал эринд финтек хувьслаар манлайлах эрхэм зорилгын хүрээнд 2023 онд дижитал шилжилтийн суурийг бэлдэж, дэд бүтэц, хүний нөөц талдаа бидний зүгээс тасралтгүй хөрөнгө оруулалтыг хийлээ.

Бид 2023 онд Тогтвортой санхүүжилтийг дэмжих үүднээс Бизнесийн зээлийн харилцагч нарын БОНЗ-н үнэлгээ хийх процессийг нэвтрүүлж, автоматаар таних боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн ногоон санхүүжилтийн хүрээнд “Чип төсөл” бүтээгдэхүүнийг ТоС холбоотой хамтран зах зээлд гаргасан. Нийт зээлийн багцын 19% хувийг ногоон зээлийн багцад төвлөрүүлэн амжилттай ажиллаа.

Цаашид бид тогтвортой санхүүжилтийн зорилт, зарчмуудын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ажилтан, харилцагч, хамтрагч түншүүддээ бүтээгдэхүүн үйлчилгээ, дотоод процессийг дижиталжуулан санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, ажилтан харилцагч бүрд тогтвортой санхүүжилтийн мэдлэг мэдээллийг түгээж ажиллахаар зорьж байна.

Хүндэтгэсэн,
“НЭТКАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ” ХХК-ийн **Гүйцэтгэх захирал Б.Хуншагай**



БОНЗ –ЫН ХӨГЖИЛ

100K+

Харилцагчийн тоо

400+

Хүний нөөц

2020

ТоС холбоонд үндсэн гишүүнээр элсэж, ТоС 8 зарчмыг хэрэгжүүлж ажиллаж эхлэв

2021

ТоС-н 8 зарчмын хүрээнд байгаль орчин нийгмийн бодлогыг анхлан батлав

2022

Монгол улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийг хангах, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн зорилгуудыг биелүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор "Тогтвортой санхүүжилтийн бодлого"-г шинэчлэн батлав.

2023

БОНЗ-н үнэлгээ хийх шаардлагатай зээлийг автоматаар танидаг болов. Анхны ногоон зээлийн "Чип төсөл" бүтээгдэхүүнийг ТоС холбоотой хамтран зах зээлд гаргав.

2023

ОНЫ ГОЛ ДҮНГҮҮД

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



2023 онд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Корбанкны системийг хөгжүүлэн нэвтрүүлэв.

БОН ҮНЭЛГЭЭ



Нийт 201 харилцагчийн зээлийн хүсэлтэд БОН-ийн нарийвчилсан эрсдэлийн үнэлгээг хийж зөвлөмжөөр хангасан.

АЖЛЫН БАЙР



Шинээр нийт 7 салбарыг нэгэн зэрэг нээж, 40+ ажлын байрыг бий болголоо.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




2023 онд нийт 22 харилцагчийн гомдол хүлээн авч гомдлыг 100% шийдвэрлэсэн ба гомдол шийдвэрлэлтийн хугацааг 40 дахин бууруулсан.

ЦААС ХЭМНЭЛТ



Дижитал зээлийг олгосноор нийт 864,000 хуудас цаасыг хэмнэж ажилласан.

БОНЗ БҮТЭЦ БА **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**



ЁС ЗҮЙН ДҮРЭМ



Манай группийн ёс зүйн дүрмийн зорилго нь ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоох, энэ талаар чиглүүлэн, дагаж мөрдүүлэхэд оршдог.

Эрсдэлийн удирдлагын газраас 2023 онд "Ёс зүйн дүрэм"-ийг хэвшүүлэх зорилгоор орон нутгийн 8 салбарын 70 ажилтан, Хотын салбаруудын шинэ зээлийн 60 ажиллагсад танхимын сургалт зохион байгуулсан.

Net Academy - Шинэ ажилтны сургалтыг хагас жил тутам зохион байгуулдаг.

АВЛИГА ЗЭЭЛ ХАХУУЛИЙН

ЭСРЭГ

"Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК" нь зүй бус бэлэг урамшууллаас татгалзаж хээл хахуулиас ангид байхыг ёс зүйн дүрэмдээ тусгасан байдаг бөгөөд шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн дээдэлж, бүхий л үйл ажиллагаандаа авлига, хээл хахуулийг огт хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд нийт ажилтан, эрх бүхий албан тушаалтнууд нь авлига, хээл хахуулийн асуудалд аливаа байдлаар холбогдох, ашиг хонжоо олж авахыг хориглосон байдаг.

СЗХ 2023 онд ББСБ, Даатгал, ХОМК-иудад дахин компанийн засаглалын зайны үнэлгээг хийж, хэрэгжилтийн үнэлгээний тайлан гаргасан ба “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК нь 2 дах жилдээ салбартаа үнэлгээгээр тэргүүлэгч топ 5н нэг болсон.

КОДЕКС ҮНЭЛГЭЭ 2022 - 84,7%

КОДЕКС ҮНЭЛГЭЭ 2023 - 94,4%

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЁС ЗҮЙН
ДҮРЭМ

ЗЭЭЛИЙН
БОНЗ
ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН
ЖУРАМ

ШҮГЭЛ
ҮЛЭЭХ
БОДЛОГО


НИЙЦЛИЙН
ЭРСДЭЛИЙН
ЕРӨНХИЙ
ЖУРАМ

ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙН
БОДЛОГО

ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН
ЕРӨНХИЙ
ЖУРАМ

ЗАХИРАЛ, УДИРДЛАГУУДЫН (61)


хүйсийн ялгаа




Эр Эм

НИЙТ АЖИЛТНУУДЫН (561)

хүйсийн ялгаа



Эр Эм



ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Нэткапитал санхүүгийн групп нь нийгэмд тулгамдаад буй жендерийн эрх тэгш байдал, ажлын байрны хомсдол зэрэгт хувь нэмрээ оруулж ажиллахыг эрмэлздэг бөгөөд үүний хүрээнд Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэмд тусгасан байдаг ба “Жендерийн тэгш байдлын бодлого”-г боловсруулан ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА САНХҮҮЖИЛТ



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



2022 онд Чанарын Удирдлагын Тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж байсан бол ийнхүү 2023 оны босго дээр Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцооны ISO/IEC 27001:2013 олон улсын стандартыг нэвтрүүлж сертификатаа гардан авч Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хоёр стандарттай болсон.



БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

ШИНЭ САЛБАР - ШИНЭ МОДОД

Бид байгаль хамгаалалын хүрээнд шинэ салбарын нээлтэнд зориулж мод тарих уламжлалыг дотооддоо нэвтрүүлэн ажилладаг.

ЦААС ХЭМНЭЛТ БА ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ

NetPay апп-аар дамжуулж нийт 82,000 хүнд дижитал зээл олгосон.

Нэг зээл бүрт – 10 хуудас бүхий цаас хэмнэдэг
Нийт - 820,000 хуудас цаас /1,5 тн нүүрс хүчлийн хийг хэмнэж чадсан.

2023 оны хүрээнд нийт 805 кг цаасыг өндөгний сав болж дахин боловруулах үйлдвэрт тушаасан.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙГЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ ЗОРИЛГЫНХОО ХҮРЭЭНД ХОГ ХАЯГДЛАА АНГИЛЖ БАЙНА.

НОГООН ОФФИС болгох үүднээс хэрэгжүүлэхээр зорьж буй алхмууд:

- Өдөр бүр 30мин ~1 цагийн турш тасалгааны гэрэл, цахилгаан хэрэгслүүдээ унтрааж хэвших.
- Оффисын бичиг хэрэгслийг ногоон худалдан авалтаар солих.
- Нийт ажилчдыг тогтвортой санхүүжилттэй холбоотойгоор заавар дүрэм журмын талаар дадлыг хэрэгжүүлэн ажиллах.

**13 МОД,
21400 ЛИТР УС**

СУРГАЛТ, ХӨГЖИЛ ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

2023 онд байгууллагийн хэмжээнд нийт 17 удаагийн дотоод сургалтыг хотын болон орон нутгийн ажилтнуудад зохион байгуулж ажилласан.

Мөн байгаль орчин, нийгэм, засаглал, комплаенстай холбоотой 13 сургалтад шаардлагатай ажилтнуудыг хамруулан сертификат авсан.

АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРҮҮД


Уян хатан ажлын цаг
Өглөөний цай хөтөлбөр

Сонирхол дэмжих хөтөлбөрүүд

- **СПОРТ ХӨТӨЛБӨР/ ХӨНГӨЛӨЛТ**
- **NC LEAGUE**
- **NETX**
- **NETVIBE**
- **QUIZ NIGHT**

Холбогдох дүрэм журмууд

- **ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО**
- **ЁС ЗҮЙН ДҮРЭМ**



ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Тусгай хэрэгцээт ажилтанд зориулсан ажлын байраар хангадаг
- Булган аймгийн төвд 7 цэцэрлэгт ариутгагч кварц гэрэл, агаар чийгшүүлэгчийн хамт хандивлав
- Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн хашаанд амарч суух, агаарлах зориулалттай 2ш сүүдрэвчийг тохижуулав.
- Налайх дүүргийн ТҮК-д багаж хэрэгсэл хандивлав.
- Багануур дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт нярайн шарлагын 3ш аппарат, утлагын 3ш аппарат хандивлав.
- Хэнтий аймагт төв зам дагуу 100м талбайд 30ш нарс мод тарьж, тус талбайг гэрлээр тойруулан тохижуулав.
- Сүхбаатар аймагт 2023 оныг хүүхэд хөгжлийн жил болгон зарласантай холбоотой аймгийн биеийн тамир спортын газарт сагс, волейболын бөмбөг болон бусад хэрэгслийг хандивлав.
- Дундговь аймгийн ид шидийн оронд хүүхдүүдэд зориулан шатар, шатрын цаг, нүүдэл заах хөөсөнцөр самбар, ханын шатар зэрэг зүйлсийг хандивлав.
- 06-н сарын 01-ыг тохиолдуулан Ид шидийн орны хүүхдүүдийн дунд “Дижитал эриний хүүхдүүд” гар зургийн уралдааныг зарлан, насны ангиллаар шалгаруулж унадаг дугуй, номын эрхийн бичиг, бэлгийн багц өгсөн.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

НИЙТ ХАРИЛЦАГЧИЙН ТОО


100,000+

2023 онд ирсэн нийт Санал хүсэлтийн тоо – 596

2023 онд ирсэн нийт Гомдлын тоо - 22

2023 онд харилцагчаас ирсэн нийт 22 гомдлыг “Харилцагчийн гомдол, санал, хүсэлт шийдвэрлэх журам”-д заасны дагуу 3 цагийн дотор шийдвэрлэн, хариу өгч ажилласан.

2023 онд харилцагчаас ирсэн санал хүсэлт ба гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан болно.



ГОМДЛЫН УДИРДЛАГА

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭ СТАНДАРТЫГ БАТАЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨЖ ЭХЭЛЛЭЭ. ИНГЭСНЭЭР ХАРИЛЦАГЧИЙН ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ДУНДАЖ ХУГАЦАА 48 ЦАГ БАЙСНЫГ 1.2 ЦАГ БОЛГОЖ БУУРУУЛЛАА.





ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НЭТКАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ ХХК

Тогтвортой санхүүжилтийн бодлого нь Группээс Монгол Улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийг хангах, байгаль орчин, нийгэм, засаглал, тогтвортой хөгжил ба уур амьсгалын зорилгуудыг биелүүлэхэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тогтвортой санхүүжилт хэсэгт дараах чиглэлийн ажлууд багтдаг. Үүнд:

- Зээлийн эх үүсвэр татах
- Ногоон бизнес эрхлэгч, хувь хүмүүст зориулсан ногоон зээл олгох
- Зээлийн хүсэлтүүдэд Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ хийх
- Бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг ажлууд багтана

БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Get It
NetPay

NetPay – аппликейшнаар дамжуулан нэг удаа гэрээ хийгээд дэлхийн хаанаас ч, хэзээ ч зээл авах боломжтой дижитал бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Нийгэм засаглалын хүрээнд тогтвортой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол улсын **21 аймаг болон 8 дүүрэгт** үйл ажиллагаагаа явуулж цэцэрлэг, эмнэлэг, нийтийн аж ахуй, нийгмийн эрүүл мэнд, мод тарих чиглэлээр ажлууд гүйцэтгэж байна.

НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

Компанийн нийт зээлийн багцын **19** хувийг ногоон зээлийн багц эзэлдэг.

НОГООН ЗЭЭЛ

Автомашинуы зээл /hybrid/
Чип, монгол гэрийн халаалт,
дулаалгын багц
Дижитал бараа
Өрхийн зээл


ЗЭЭЛИЙН БАГЦ

21.4 Тэрбум
2.7 Сая
9.5 Сая
56.8 Сая



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА

Групп нь нийгмийн хариуцлагын ажлуудыг жил бүр зохион байгуулж, зохих төсвийг батлан ажилладаг бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх үйл ажиллагаанууд нь тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг үйл ажиллагаанууд байдаг. Бид тогтвортой хөгжлийн алсын хараанд дараах ажлуудыг тусган ажиллаж байна.




Хийгдэх ажлууд

Ажлын байрыг нэмэгдүүлэх
Ногоон зээл олголтыг нэмэгдүүлэх
Жишиг ногоон оффис бий болгох

Агаарын бохирдлыг бууруулах ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргах гэх мэт

**ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙН
БОДЛОГО
БА ХИЙГДЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА**



Энэхүү бодлого нь Монгол Улсын Засгийн газраас баримталж буй “Алсын хараа 2050”, “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг 2030” болон “Үндэсний ногоон таксономи” баримт бичгүүдтэй нийцсэн байдаг ба цаашид шаардлагатай хугацаанд шинэчлэн, мөрдөж ажиллана.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

- Хариуцлагатай бизнесийг дэмжих
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Зээлийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ
- ОУ-ын санхүүгийн байгууллагуудын харилцаа ба санхүүжилт
- ОУ-ын ба дотоодын тогтвортой санхүүжилтийн санаачилгууд

ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Компанийн нийгмийн хариуцлагын стратеги болон сангийн үйл ажиллагаа
- Компанийн нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүд



ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТАЙЛАГНАЛ

- Үйл ажиллагааны, санхүүгийн, Тогтвортой хөгжлийн жилийн тайлангууд
- Хөрөнгө оруулагч, хамтрагч, зохицуулагч байгууллагуудын асуулга, тайлан
- Аудит ба оролцогч талуудын оролцоо

ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Хүний нөөцийн бодлого ба тогтвортой ажлын байр
- Компанийн засаглал
- Байгальд ээлтэй ажлын орчин
- Олон талт болон хүртээмжтэй үйл ажиллагаа, үйлчилгээ
- Мэдээллийн аюулгүй байдал ба хяналт шалгалт
- Дотоодын журамд Тогтвортой хөгжлийн зорилгуудыг уялдуулах





NET CAPITAL
financial group

ГАЛ ЭРМЭЛЗЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛ



NETCAPITAL.MN



7500-6666



ШАНГРИ-ЛА ОФФИС 2201 ТООТ